



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.05.08 № 01/107 ВАГ-ГАГ/2013/02-ГА

Зөрчил арилгуулах тухай

ССАЖЯ-ны салбарын 2012 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн үр дүнд хийсэн аудитаар мэргэжлийн урлагийн байгууллагуудад 449.7 сая төгрөгийн үнэ бүхий рояль хөгжим нийлүүлэгдээгүй байхад урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулж санхүүжилт хийсэн,

Соёл урлагийн байгууллагуудад нийлүүлэх 580 сая төгрөгийн өртөгтэй гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжийг гүйцэтгэгчийн агуулахад удаан хадгалуулж хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулсан;

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж чадаагүй хугацаа алдсанаас зарим шинээр баригдах театр, соёлын төвийн барилгын ажлын нийт 2,710.3 төгрөгийг улсын төсөвт буцаан татуулсан,

Гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй олон жил удааширсанаас зарим барилгын төсөвт өртөг нэмэгдэж, үр ашиггүй хөрөнгө оруулалт болсон зэрэг зөрчил, дутагдлууд илэрлээ.

Иймд төрийн аудитын тухай хуулийн 15.1.12 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ыг үндэслэн АЛБАН ШААРДЛАГА ХҮРГҮҮЛЭХ НЬ:

1. 2013 оны 6 сард багтаан гүйцэтгэгч "ХАЗААРБАТ" ХХК-иар рояль хөгжмийг мэргэжлийн урлагийн байгууллагад нийлүүлсэн байх арга хэмжээ авах
2. "Протек" ХХК-ны агуулахад байгаа гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжийг яаралтай татан авч зохих байгууллагад хуваарилах
3. Улсын төсөвт хөрөнгө нь буцаан татагдсан Баянхонгор аймгийн Бууцагаан, Баянговь, Орхон аймгийн Баян-Өндөр сумын Шанд багийн соёлын төвийн барилга, Дундговь аймгийн төв халхын дуулалт жүжгийн театрын барилгын ажлын нийт 2,710.3 сая төгрөгийг 2013 оны улсын төсвийн тодотголд буцаан тусгуулж хөрөнгийг шийдвэрлэх
4. Говь-Алтай аймгийн Алтай чуулгын байр, нийслэлийн Сонгино хайрхан дүүргийн 700 хүний суудалтай спортын ордон, Гандантэгчилэн хийдийн 1080 суудалтай ергэтгелийн барилгын ажлуудыг гэрээний хугацаанд дуусгах, гэрээнд заасны дагуу хугацаа алдсан зөрчилд алданги тооцох

Эдгээр зөрчлийг арилгуулж, гүйцэтгэлийг 2013 онд багтаан хэрэгжүүлж, захиалагчийн гэрээний нөхцлийг хангуулж ажиллахыг ССАЖ-ын сайд Ц.Оюунгэрэлд хариуцуулан албан шаардлага хүргүүлж байна.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

Гүйцэтгэлийн аудитын газрын  
Ахлах аудитор *Ж.Эрдэнэ* Ж.Эрдэнэ

УХА0122

A red square stamp containing Mongolian text. At the top, it reads "АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:". Below this, there is a signature in cursive script, which is identified as "Ж.Эрдэнэ" (J. Erdene) in the printed text to the right. The stamp also contains the text "Гүйцэтгэлийн аудитын газрын Ахлах аудитор" (Chief Auditor of the Implementation Audit Department) and the alphanumeric code "УХА0122" at the bottom.